

ЗӨВШӨӨРЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮҮРЭГ ХҮЛЭЭСЭН:

“МОНГОЛЫН АЛТ” (МАК) ХХК - НИЙ  
ЕВРО БЛОК ҮЙЛДВЭРИЙН ДАРГА



Б. ЦЭРЭНБАТ

**ТӨВ АЙМГИЙН СЭРГЭЛЭН СУМЫН НУТАГТ БАЙРЛАХ  
МАК ЕВРО БЛОК ҮЙЛДВЭРИЙН 2026 ОНЫ БАЙГАЛЬ  
ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

/АЖ АХУЙН НЭГЖИЙН РЕГИСТРИЙН ДУГААР: 2095025/

БОЛОВСРУУЛСАН:

МАК Евро блок үйлдвэрийн байгаль орчин  
тогтвортой хөгжлийн ахлах мэргэжилтэн

Б. Жавзан

2026 он

## АГУУЛГА

|                                                                                                                                                      |    |
|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|----|
| 1. ОРШИЛ.....                                                                                                                                        | 2  |
| 2. ҮЙЛДВЭРИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА.....                                                                                                                  | 3  |
| 3. ҮЙЛДВЭРИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ТОВЧ<br>ТОДОРХОЙЛОЛТ.....                                                                          | 11 |
| 4. ҮЙЛДВЭРИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ<br>ТОДОРХОЙЛОЛТ.....                                                                            | 14 |
| 5. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ<br>ГОЛ ЗОРИЛТ.....                                                                         | 18 |
| 6. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ.....                                                                                         | 19 |
| 7. ОРЧНЫ ТОХИЖИЛТ ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.....                                                                                                 | 23 |
| 8. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ.....                                                                                       | 24 |
| 9. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.....                                                                                                      | 25 |
| 10. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.....                                                                                                       | 29 |
| 11. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР.....                                                                                                          | 31 |
| 12. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ<br>ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ.....                                | 30 |
| 13. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ<br>ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨГЧ ОРШИН СУУГЧИД, ОРОЛЦОГЧ<br>ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ ХУВААРЬ..... | 33 |
| 14. БАЙГАЛЬ ОРЧНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ НИЙТ ЗАРДАЛ.....                                                                                                     | 33 |

### НЭГ. ОРШИЛ

2026 оны Евро блок үйлдвэрийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг 2022 онд батлагдсан үйлдвэрийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлан, өмнөх жилүүдийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг үндэслэсэн БОАЖЯ-ийн сайдын 2019 оны 10 сарын 29 -ны өдрийн № А/618 тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын 1, 3 дугаар хавсралтын дагуу боловсруулав.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг дүгнэх Төв аймгийн ажлын хэсэг 2025 оны төлөвлөгөөний хэрэгжилттэй танилцаж 95,33 % буюу хангалттай гэсэн үнэлгээ өгсөн.

Энэхүү Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь зөвхөн үйлдвэрийн 2026 оны үйл ажиллагааны хүрээнд хамаарах хэсгүүдтэй уялдан хийгдсэн бөгөөд тус төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд **14,764,200.00** төгрөг зарцуулахаар байна.

## ХОЁР. ҮЙЛДВЭРИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

### Компанийн танилцуулга:

“Монголын Алт” (МАК) ХХК нь 1993 онд үүсгэн байгуулагдсан, үндэсний хөрөнгө оруулалттай, Монгол улсын тэргүүлэх компаниудын нэг билээ. Манай компани уул уурхай, барилгын материал үйлдвэрлэл, хөдөө аж ахуй, агаарын тээвэр, үл хөдлөх хөрөнгө, хэвлэл мэдээлэл зэрэг чиглэлээр үйл ажиллагаагаа явуулж байна.

Үйл ажиллагааныхаа туршид улс, орон нутгийн төсөвт татвар төлөлтөөрөө тогтмол тэргүүлж ирсэн бөгөөд байгаль орчинд сөрөг нөлөө багатай, дэлхийд тэргүүлэх сүүлийн үеийн дэвшилтэт техник технологийг үйл ажиллагаа, үйлдвэрлэлдээ нэвтрүүлж, улс эх орныхоо хөгжил, эдийн засагт даацтай хувь нэмэр оруулах томоохон төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж байна.

### 2.1 Товч танилцуулга

Евро блок үйлдвэр нь ХБНГУ-ын “ТОПВЕРК” группийн “Хесс ААС Системс”-ийн дэвшилтэт технологиор жилд 270000 м<sup>3</sup> сайн чанарын блок үйлдвэрлэн зах зээлд нийлүүлэх зорилготойгоор 2015 оны 6 сард бүрэн ашиглалтад орж бүтээгдэхүүн үйлдвэрлэж эхэлсэн.

Үйлдвэрийн нэр: Евро блок үйлдвэр

Ангилал: Дэд бүтцийн хөгжил

Үйлдвэр эзэмшигчийн “Монголын Алт” (МАК) ХХК

нэр: Улсын бүртгэлийн дугаар: 9011071054

Регистрийн дугаар: 2095025

Хаяг:

Хан-Уул дүүрэг, 1-р хороо, XIX хороолол, Чингисийн өргөн чөлөө, “Монголын Алт” (МАК) ХХК-ийн төв байр-44

Утас: 75759700, факс: 70107481

Хүснэгт 1 Эдэлбэр газрын эргэлтийн цэгүүд

| №                   | Уртраг (град, мин, сек) | Өргөрөг (град, мин, сек) | Цэг | Зай, м |
|---------------------|-------------------------|--------------------------|-----|--------|
| <b>11 га талбай</b> |                         |                          |     |        |
| 1                   | 107° 12' 40.4 "         | 47° 41' 46.79"           | 1-2 | 598.35 |
| 2                   | 107° 12' 30.49 "        | 47° 42' 4.96"            | 2-3 | 145.74 |
| 3                   | 107° 12' 37.00"         | 47° 42' 6.5"             | 3-4 | 557.41 |
| 4                   | 107° 12' 50.19 "        | 47° 41' 50.78"           | 4-1 | 238.42 |
| <b>1 га талбай</b>  |                         |                          |     |        |

|   |                  |                 |     |        |
|---|------------------|-----------------|-----|--------|
| 1 | 107° 12' 50.8 "  | 47° 41' 51.01 " | 1-2 | 156.51 |
| 2 | 107° 12' 47.19 " | 47° 41' 55.45 " | 2-3 | 61.34  |
| 3 | 107° 12' 49.81 " | 47° 41' 56.34 " | 3-4 | 149.12 |
| 4 | 107° 12' 53.6 "  | 47° 41' 52.25 " | 4-1 | 69.88  |

**Үйлдвэрийн байршил:** Төв аймгийн Сэргэлэн сум 1-р багт Улаанбаатар хотоос зүүн урагш 40 км зайд, төмөр замын Баян зөрлөгийн дэргэд тус сумын Засаг Даргын 2011 оны 02-р сарын 16-ны өдрийн 19 тоот шийдвэрээр бетоны үйлдвэрлэлийн зориулалтаар 11 га, 2014 оны 06 сарын 13-ны өдрийн 129 тоот шийдвэрээр үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар 1 га, нийт 12 га талбайг эзэмшиж байна.



Зураг 1 Үйлдвэрийн байршил

## 2.2 Үйлдвэрийн хүчин чадал

“Монголын Алт” (МАК) ХХК нь “Евро блок үйлдвэр” –т Германы HESS группээс хоногт 900м<sup>3</sup> (цаашид хоногт 1550м<sup>3</sup> болтол өргөтгөх боломжтой) хийт бетон үйлдвэрлэх хүчин чадалтай үйлдвэрийн тоног төхөөрөмж суурилуулсан.

|                             |         |
|-----------------------------|---------|
| Үйлдвэрийн шугам            | КВТ 900 |
| Хоногт ажиллах ээлжийн тоо: | 2       |
| Ээлжийн ажиллах хугацаа:    | 12 цаг  |
| Автоклавын циклийн хугацаа: | 12 цаг  |

|                          |                        |
|--------------------------|------------------------|
| Жилд ажиллах өдрийн тоо: | 300 өдөр               |
| Жилийн хүчин чадал:      | 270 000 м <sup>3</sup> |



*Зураг 2 Евро блок үйлдвэрийн харагдах байдал*

#### ***Ажиллах хүч***


Үйлдвэрт нийт 290 ажилчнаас 190 орчим хүн өдөр, шөнийн ээлжинд 30-40 хүн ажиллана. Ээлжийн мастер, тоног төхөөрөмжийн оператор, засварчин, тогооч, угаагч, үйлчлэгч гэх мэт тасралтгүй үргэлжилсэн ажилтай хүмүүсийг солигдох ээлжтэй буюу амралттайгаар инженер техникийн ажилчид болон удирдлагууд солигдох ээлжгүйгээр ажиллана.

#### **Технологийн үйл ажиллагааны үндсэн зарчим**

Евро блок үйлдвэрлэх технологи нь манай оронд байгаа адил төрлийн технологитой харьцуулахад дараах давуу талуудтай. Үүнд:

1. Үйлдвэрлэх бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлэх, хүчин чадлыг өргөтгөх боломжтой.
2. Үйлдвэрлэж байгаа бүтээгдэхүүний хэмжээний хэлбэлзлийн хүлцэх алдаа бага ( $\pm 1.5$  мм-ээс ихгүй), нарийвчлал өндөр.
3. Олон улсын болон европын стандартчиллын холбоо (CEM, EN)-ны шаардлагын төвшинд хүрсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх боломжтой.
4. Бүтээгдэхүүний сав баглаа, боодлыг олон улсын шаардлагын хэмжээнд шийдвэрлэсэн.
5. Бүтээгдэхүүнийг зөөвөрлөх, зүсэх ажиллагааны технологийн зохицолдолгооны шийдэл сайтай.

Схем 1. Үйлдвэрийн технологи



### 2.3 Төслийн тоног төхөөрөмж, техник болон дэд бүтэц

**Тоног төхөөрөмж:** Германы HESS группээс хоногт 900м<sup>3</sup> (цаашид хоногт 1550м<sup>3</sup> болтол өргөтгөх боломжтой) блок үйлдвэрлэх КВТ 900 үйлдвэрийн шугамыг суурилуулсан.

**Цахилгаан, хангамж:** Үйлдвэрийн цахилгааны суурилагдсан хүчин чадал 3.2 мВт, үйлдвэрийн хүчдэл 400+5% VAC, 3 фаз + PE, 50Гц ±5%.

Хүснэгт 2 Цахилгааны хэрэглээ

| Цахилгааны хэрэглээ, кВт*Ц | 1 м <sup>3</sup> Хийт бетонд | Жилийн хэрэглээ КВТ-900 |
|----------------------------|------------------------------|-------------------------|
|                            | 19.5                         | 5264000                 |

Үйлдвэрээс 16.6 км зайд байрлах Налайхын дэд станцаас 35кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам татан үйлдвэрт шаардлагатай цахилгааны хэрэглээг хангаж байна.



Зураг 3 Цахилгааны 35/0,4 кВ-ын дэд станц

**Зам тээвэр:** Улаанбаатар хотоос 45 км, Налайх дүүргээс 10 км зайтай Улаанбаатар – Замын үүд чиглэлийн олон улсын чанартай авто замаас 700 метр засмал замаар явж хүрнэ. Үйлдвэрийн түүхий эд болон бэлэн бүтээгдэхүүний тээвэрлэлтийн нөхцөлийг доорх хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт 3 Тээвэрлэлтийн нөхцөл

| Материал | Хэмжих нэгж | Зай, км | Тээврийн хэрэгсэл     | Тээвэрлэх хэмжээ |                 | Тайлбар                                       |
|----------|-------------|---------|-----------------------|------------------|-----------------|-----------------------------------------------|
|          |             |         |                       | Хоногт           | 7 хоногт        |                                               |
| Элс      | тн          | 35      | Авто машин            | 15               | 102             | Дэнжийн элсний орд, Налайх                    |
| Шохой    | тн          | 280     | Галт тэрэг            | 1                | 7               | МАК-ын цементийн үйлдвэр, 25-р зөрлөг         |
| Цемент   | тн          | 280     | Галт тэрэг            | 2                | 12              | МАК-ын шохойн үйлдвэр, 25-р зөрлөг            |
| Гөлтгөнө | тн          | 280     | Галт тэрэг, автомашин | 0                | 2               | Ширээгийн хөндийн гөлтгөнийн орд, 25-р зөрлөг |
| Нүүрс    | тн          | 10, 450 | Галт тэрэг, автомашин | 37,1тн<br>12,8   | 4 вагон<br>90тн | Налайх, Хөөт                                  |

## 2.4. Төслийн түүхий эд, туслах материал, эцсийн бүтээгдэхүүн

### 2.4.1. Байгалийн гаралтай түүхий эд

**Элс:** Налайх дүүрэгт байрлах Дэнжийн элс-1 ордоос автомашинаар тээвэрлэн ирсэн элсийг үйлдвэр доторх агуулахад хадгалах ба шанагат ачигчаар элс түр хадгалах бункерт өгч туузан дамжуулагчаар дамжуулан бөмбөлөгт тээрэмд ачаална.

**Шохой:** Евро блок үйлдвэр хоногт 62 тн шохой хэрэглэх бөгөөд шохойг Хөтөл ХК-ийн шохойн үйлдвэрээс галт тэргээр тээвэрлэнэ. Галт тэргээр хүлээн авсан шохойг ус чийгээс хамгаалсан битүүмжлэлтэй агуулахад хадгалах бөгөөд технологийн шохойг урьдчилан буталсны дараа бөмбөлөгт тээрэмд тээрэмдэж зохих хувийн гадаргуутай болтол нунтаглан ажлын силост хадгална.



*Зураг 4 Шохой буулгах, хадгалах битүү агуулах*

**Гөлтгөнө:** Евро блокны үйлдвэр нь хоногт 18 тонн гөлтгөнө хэрэглэх бөгөөд үйлдвэрт шаардлагатай гөлтгөнийг МАК Цементийн үйлдвэрээс галт тэргээр болон автомашинаар тээвэрлэнэ гэж тооцвол 7 хоногт 2 вагон гөлтгөнө хэрэглэнэ. Галт тэргэнээс хүлээн авсан гөлтгөнийг задгай агуулахад хадгалах бөгөөд 5мм-ээс жижиг ширхэгтэй болтол буталсаны дараа бөмбөлөгт тээрэмд элстэй хамт өгч нунтаглана.



*Зураг 5 Гөлтгөнө хадгалах задгай талбай*

**Нүүрс:** Налайхын уурхайн нүүрсийг хэрэглэх бөгөөд нүүрсний илчлэг 3400-3500 ккал/кг, ба чийглэг 8.5%, үнслэг 10-33.3%, дэгдэмхий бодисын агуулга 22.0-34.1% байна. 1 өдрийн хугацаанд нүүрсний зарцуулалт өдөрт 6 тонн 1 сарын хугацаанд 180 тн байна.

**Ус:** Усны хэрэглээг багасгах зорилгоор үйлдвэрийн технологийн үйл ажиллагаанаас гарч буй конденсацын усыг цэвэршүүлэн шүүн зөөлрүүлэх системийн тусламжтайгаар MNS 6734:2018 стандартын шаардлагад нийцүүлэн цэвэршүүлж үйлдвэрийн технологид ашиглаж эхэлсэн ба 1 м3 бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд 12 % нь цэвэр ус, 88 % нь конденсацын усыг ашиглаж байна. Евро блок үйлдвэрлэхэд хэрэглэх ус нь ямар нэгэн хортой хольц агуулаагүй рН нь 7-8.3 байна.

## 2.5 Бусад түүхий эд

Бусад түүхий эдэд цемент, хөнгөн цагааны нунтаг орно.

**Цемент:** Евро блок үйлдвэр хоногт 89 тонн цемент хэрэглэх бөгөөд цементийг МАК Цементийн үйлдвэрээс галт тэргээр тээвэрлэнэ. Галт тэргээр хүлээн авсан задгай цементийг хийн тээврийн төхөөрөмжөөр буулган цементийн силост (агуулахад) хадгална. Цементийн силосоос ажлын силос руу хийн тээврээр тээвэрлэн тунгааж хэрэглэнэ.



*Зураг 6 Цемент буулгах хэсэг болон хадгалах силос*

## **Хөнгөн цагааны нунтаг:**

Үйлдвэр нь жилд 120 тн хөнгөн цагааны нунтагийг Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас олгосон “Химийн хорт болон аюултай бодисыг экспортлох, импортлох, хил дамжуулан тээвэрлэх, үйлдвэрлэх, ашиглах, худалдах аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн дагуу худалдан авч “MNS 6458:2014 Химийн хорт бодис бүтээгдэхүүний агуулах, ерөнхий

шаардлага”-д нийцүүлэн тусгай зориулалтын **6\*10** метр хэмжээтэй агуулахад хадгалан үйлдвэрийн түүхий эдэд ашиглаж байна



Зураг 7 Химийн бодисын агуулах болон бодисын савалгаа

## 2.6 Эцсийн бүтээгдэхүүн

“Монголын Алт” (МАК) ХХК-ийн “Евро блок үйлдвэр” нь хоногт 292 тн элс, 62 тн шохой, 89 тн цемент, 18 тн гөлтгөнөөр 900м<sup>3</sup> бетон үйлдвэрлэнэ.

Хүснэгт 4 Түүхий эдийн хэрэглээ

| Түүхий эд материалын нэр | Хэмжих нэгж | Хэрэглээ |          |
|--------------------------|-------------|----------|----------|
|                          |             | Хоногт   | 7 хоногт |
| Элс                      | тн          | 292.0    | 2044     |
| Шохой                    | тн          | 62.0     | 434      |
| Цемент                   | тн          | 89.0     | 693      |
| Гөлтгөнө                 | тн          | 18.0     | 126      |



Зураг 8 Бэлэн бүтээгдэхүүн

**Нэгдсэн менежментийн тогтолцоо:** Манай үйлдвэр нь 2022 оны 12 сарын 30 нд **ISO 9001:2015** “Чанарын менежментийн тогтолцоо”, **ISO 45001:2018** “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн менежментийн тогтолцоо, **ISO 14001:2015** Байгаль орчны менежментийн тогтолцоо олон улсын стандартуудын аудитаа амжилттай хамгаалж баталгаажуулалтын гэрчилгээг гардан авч нэгдсэн менежментийн тогтолцоог хэрэгжүүлэн ажиллаж байна.




**Зураг:9 Нэгдсэн менежментийн тогтолцооны баталгаажуулалтын гэрчилгээ**

## ГУРАВ. БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

### 3.1 Үйлдвэрийн талбайн хөрсөн бүрхэвчийн төлөв байдал

Баянгийн зөрлөг орчим нь Төв аймгийн зүүн хойд хэсэгт орших бөгөөд Монгол орны хөрс-газар зүйн мужлалаар Хангайн их мужийн өндрийн бүсчлэлийн дэд бүсийн Хэнтийн захын 39-р тойрогт хамаарагдана.



**Зураг 10 Монгол орны хөрс газар зүйн мужлал**

**Үйлдвэрийн эзэмшил талбайд карбонатлаг уулын хар шороон хөрс тархсан.**

**Уулын хар шороон хөрс:** Уулын орой хяр болон хажуугийн дээд биеэр хэмхдэс чулуу ихтэй элювий, делювийн нимгэн хурдас дээр байрлах тул хөрсний үе давхаргууд нь нимгэн, сайр чулуурхаг шинжтэй. Үржил шим бүхий ялзмагт А давхаргын зузаан 8-9 см орчим. Нунтаг шорооны ширхгийн бүрэлдэхүүн нь нимгэн шаварлаг хэсгийн эзлэх хувь 20-24% хөрсний доод хэсэгт 25-28 см-ийн гүнээс доош карбонатын хуримтлалын Вса, Сса давхарга үүсэж, CO<sub>2</sub>-ын агууламж 1.8-4.1% байх бөгөөд үүний улмаас хөрсний доод давхарга нь сулавтар шүлтлэг, дээд хэсэг нь саармаг орчинтой. Ялзмаг хуримтлалын ба карбонат хуримтлалын давхарга хооронд шилжилтийн, карбонатгүй, 1.8-3.3 ялзмагтай сайр чулуурхаг үе /AB, BC/ тогтсон. Ургамалд шаардагдах шим тэжээлийн элементийн хангамж дунд зэрэг, тухайлбал: 100 гр хөрсөнд хөдөлгөөнт азот 3-4 мг, фосфор 2 мг, калий 25-30 мг орчим хэмжээтэй агуулагдана. Хөрсний үржил шимийн нэг гол үзүүлэлт болох ялзмагийн хэмжээ хөрсний дээд давхаргад 4.5-6.3 % байна.

### **3.1.1 Ургамлан бүрхэвч**

Үйлдвэрийн эзэмшил талбайн ургамалжилтын хувьд уулын хажуу хээрийн Агь – шарилж –алаг өвст, Агь –алаг өвст, Алаг өвс-үетэнт, Агь-алаг өвс-үетэнт гэсэн 4 төрлийн хэв шинжүүд зонхилж байна. Үүнд:

**1. Уулын хажуу хээрийн Агь-шарилж-алаг өвст хэвшил:** Уулын хажуу хээрийн уг хэв шинжид Агь (*Artemisia frigida* Willd.), Адамсын шарилж (*Artemisia Adamsii* Bess.) зонхилж алаг өвснөөс Толгодын багваахай (*Taraxacum collinum* DC.), Имт гичгэнэ (*Potentilla bifurca* L.), Ишгэн шарилж (*Artemisia dracunculus* L.), Үсхий нохойн хэл (*Panzeria lanata* (L.) Bge.), Арзгар согсоот (*Heteropappus hispidus* (Thunbg.) Less.) гэсэн зүйл ургамал.

**2. Уулын хажуу хээрийн Агь –алаг өвст хэвшил:** Уулын хажуу хээрийн уг хэв шинжид Агь (*Artemisia frigida* Willd.) зонхилох алаг өвснөөс Толгодын багваахай (*Taraxacum collinum* DC.), Бургас навчит банздоо (*Saussurea salicifolia* (L.) DC.), Ишгэн шарилж (*Artemisia dracunculus* L.), Долгионтсон гишүүнэ (*Rheum undulatum* L.), Сибирь зүр өвс (*Filifolium sibiricum* (L.) Kitam.) гэсэн зүйл.

**3. Алаг өвс-үетэнт хэвшил.** Уг хэв шинжид үетэнээс Крыловын хялгана (*Stipa Krylovii* Roshev.), Нангиад Өлөн Живэр (*Tripogon chinensis* (Franch.)Hack.) алаг өвснөөс Адамсын шарилж (*Artemisia Adamsii* Bess.) зонхилж Агь (*Artemisia frigida* Willd.), Бууралдуу янгиц (*Ptilotrichum canescens* C.A.Mey.) Навтгар таван салаа (*Plantago depressa* Willd.) гэсэн зүйл.

**4. Агь-алаг өвс-үетэнт хэв шинж.** Уг хэв шинжид Агь (*Artemisia frigida* Willd.) зонхилж үетэнээс Крыловын хялгана (*Stipa Krylovii* Roshev.) алаг өвснөөс, Бууралдуу янгиц (*Ptilotrichum canescens* C.A.Mey.), Бургас навчит банздоо (*Saussurea salicifolia* (L.) DC.), Ишгүй Гичгэнэ (*Potentilla acaulis* L.), Хялгасан Дэвхэргийн цагаан (*Arenaria cappilaris* Poir.) гэсэн зүйл ургамал.

### 3.1.2 Амьтны аймаг

Суурин газрын амьдрал эхэлж, Баянгийн зөрлөг байгуулагдсанаас хойш унаган байгалийн ихэнх амьтад дайжсан учраас төслийн талбай орчимд бор туулай зэрэг амьтад, суурин газрын шувууд, мэрэгчид, шавьж л үзэгдэж байна.

### 3.2 Төв аймгийн Сэргэлэн сумын нийгэм эдийн засгийн байдал

Төв аймгийн Сэргэлэн сум нь 1924 онд байгуулагдсан, хуучнаар Түшээт хан аймгийн Дархан гүний хошуу. Баян бүрд, Хайрхан, Хөшиг, Эрдэнэ-Уул, Авдар гэсэн 5 багийн нийт 728 өрхөд 2012 хүн амьдардаг. Хүн амын тоогоор Төв аймгийн 26 сумаас 17 -д, газар нутгийн хэмжээгээр эхний 5-д ордог.

Далайн түвшинээс дээш 1000-1500 м өргөгдсөн. Газар хөдлөлийн эрчим 6,5-7 балл. Төв аймгийн Эрдэнэ, Баян, Баянцагаан, Зуун мод, Алтанбулаг гэсэн таван сум, Нийслэлийн Хан-Уул, Баянзүрх, Налайх, Багахангай гэсэн дөрвөн дүүргээр хүрээлэгддэг. Төв аймгийн зүүн урд хэсэгт Улаанбаатар хотоос 62 км, аймгийн төвөөс 12 км зайд байрладаг. Хэрлэн, Туул зэрэг том болон жижиг голуудтай. Нийт газар нутгийн хэмжээ 3865.7 га.

Хүснэгт 5 Газар нутгийн мэдээлэл

| Зориулалт                | Хэмжээ/га/ | Нийт талбайд<br>эзлэх хувь |
|--------------------------|------------|----------------------------|
| Хөдөө аж ахуйн газар     | 36446.75   | 91.8                       |
| Ойн сан бүхий газар      | 4975.80    | 1.27                       |
| Усан сан бүхий газар     | 309        | 0.08                       |
| Тусгай хэрэгцээний газар | 18201.8    | 4.71                       |
| Тосгон, суурингийн газар | 5172.76    | 1.25                       |
| Дэд бүтцийн газар        | 3448.9     | 0.8                        |

## ДӨРӨВ. ҮЙЛДВЭРИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ

Евро блок үйлдвэрийн гол ба болзошгүй сөрөг нөлөөллийг 2022 онд батлагдсан БОННУ-ний нэмэлт тодотголоор дараах байдлаар тодорхойлсон байдаг.

Байгаль орчинд үзүүлэх бохирдол, нөлөөллийн эх үүсвэр, шинж чанар, өртөгдлийн байдал

*Хүснэгт 6,7,8 Үйлдвэрийн гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл*

| Нөлөөллийг тодорхойлох шалгуур үзүүлэлтүүд                                                                                                                                                                                        | Сөрөг нөлөөлөл үүсч болзошгүй нөхцөлүүд                                                                                                                                                                                                                                                                                                                                                     |
|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| <b>Төслийн байршилтай холбоотой шалгуурууд</b>                                                                                                                                                                                    |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                             |
| Хүний нөлөө болон байгаль, цаг уурын өөрчлөлтөд эмзэг, эсэх;                                                                                                                                                                      | <ul style="list-style-type: none"> <li>- Орон нутагт салхины нөлөө ихтэй ба хүчтэй салхи шуурга үе үе болдог;</li> <li>- Үйлдвэрийн түүхий эд хураах талбай, хаягдал бетон бутлах үе шатуудаас богино хугацаанд эрчим ихтэй тоосжилт үүсэж болзошгүй;</li> <li>- Хөрсний эвдрэл үүсэж болзошгүй;</li> <li>- Газар хөдлөлтийн 8 баллын бүсэд оршиж байгаа;</li> </ul>                        |
| Орон нутгийн хэтийн хөгжилд ашиглахаар төлөвлөсөн газар байгаа эсэх                                                                                                                                                               | Үйлдвэрийн талбай нь “Алтанбулаг сумын зүүн хэсэг, Сэргэлэн, Баян, Баянцагаан сумын зүүн талын төмөр зам дагуу” нэртэй орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийн хилийн бүсэд байрлаж байна;                                                                                                                                                                                          |
| Болзошгүй хуримтлагдах нөлөөлөл үүсэх эсэх                                                                                                                                                                                        | Орон зайн хувьд нөлөөллийн цар хүрээ цаашид тэлэхгүй бөгөөд харин төсөл хэрэгжих явцад тухайн орчинд өөр төслүүд зэрэгцүүлэн хэрэгжих тохиолдолд хуримтлагдах нөлөөлөл үүсч болзошгүй.                                                                                                                                                                                                      |
| Тусгай хамгаалалттай газар нутаг, түүх, соёлын дурсгалт зүйлүүдэд нөлөөлөл үүсэх эсэх                                                                                                                                             | Үйлдвэрийн талбай нь “Алтанбулаг сумын зүүн хэсэг, Сэргэлэн, Баян, Баянцагаан сумын зүүн талын төмөр зам дагуу” нэртэй орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийн хилийн бүсэд байрлаж байна. Төслийн талбайд түүх соёлын дурсгал байхгүй.                                                                                                                                             |
| <b>Төслийн БО-ны нөлөөллийн урьдчилсан үнэлгээнд авч үзсэн асуудлууд</b>                                                                                                                                                          |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                             |
| Агаарын чанарт үзүүлэх нөлөөлөл: <ul style="list-style-type: none"> <li>• Бохирдуулагч болон аюултай, хортой бодис ялгаруулах, эсэх</li> <li>• Дуу чимээ, доргио чичиргээ, дулааны нөлөөлөл, цахилгаан соронзон цацраг</li> </ul> | <p>Агаарын чанарт сөрөг нөлөө үзүүлэх дараах эх үүсвэрүүд байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Түүхий эдийг тээвэрлэх зөөх, үйлдвэрийн бутлах, тээрэмдэх хэсгээс үүсэх тоосжилт;</li> <li>- Шаталтаас үүсэх утаа, түлшнээс үүдэлтэй хүхэр <math>SO_x</math> ба азотын <math>NO_x</math> оксид зэрэг хийн хаягдал;</li> <li>- Дуу чимээ болон доргилт үүснэ;</li> </ul> |

Төслийн байгаль орчны нөлөөллийн гол шалгуурууд болон урьдчилан тодорхойлсон сөрөг нөлөөллийн хэлбэр, эрчим, үргэлжилэх хугацааг магадлан жагсаах аргаар үнэлж дараах хүснэгтээр үзүүлж байна.

| Нөлөөллийг тодорхойлох шалгуур үзүүлэлтүүд                                           | Нөлөөллийн хэлбэр |          | Нөлөөллийн эрчим   |                         |    |                            | Үргэлжлэх хугацаа |                |               |  |
|--------------------------------------------------------------------------------------|-------------------|----------|--------------------|-------------------------|----|----------------------------|-------------------|----------------|---------------|--|
|                                                                                      | Шууд              | Шууд бус | Өөрөө эрчимлүүлэгч | Нөлөөлөл байгалийн дунд | Их | Түр зуурын (1 жилээс доош) | Богино хугацааны  | Дунд хугацааны | Урт хугацааны |  |
| Төслийн байршилтай холбоотой шалгуурууд                                              |                   |          |                    |                         |    |                            |                   |                |               |  |
| Хүний нөлөө байгаа эсэх                                                              |                   | х        |                    | х                       |    |                            | х                 |                |               |  |
| Байгаль, цаг уурын өөрчлөлтөд эмзэг, эсэх;                                           |                   | х        |                    |                         | х  |                            |                   |                | х             |  |
| Орон нутгийн хэтийн хөгжилд ашиглахаар төлөвлөсөн газар байгаа эсэх                  |                   |          | х                  | х                       |    |                            |                   |                | х             |  |
| Төслийн БО-ны нөлөөллийн урьдчилсан үнэлгээнд авч үзсэн асуудлууд                    |                   |          |                    |                         |    |                            |                   |                |               |  |
| Бохирдуулагч болон аюултай, хортой бодис ялгаруулах, эсэх                            | х                 |          |                    |                         | х  |                            |                   |                | х             |  |
| Дуу чимээ, доргио чичиргээ, дулааны нөлөөлөл, цахилгаан соронзон цацраг үүсгэх, эсэх | х                 |          |                    |                         | х  |                            |                   |                | х             |  |
| Гадаргын болон газрын доорх усны нөөцийн хомсдол үүсэх, эсэх;                        |                   | х        |                    | х                       |    |                            | х                 |                |               |  |
| Цэнгэг усны нөөцийг ашиглах, эсэх;                                                   | х                 |          |                    | х                       |    |                            |                   |                | х             |  |
| Ус бохирдуулах, эсэх;                                                                |                   | х        |                    | х                       |    |                            |                   |                | х             |  |
| Хөрс эвдрэх эсэх;                                                                    | х                 |          |                    |                         | х  |                            |                   |                | х             |  |
| Хөрс бохирдох эсэх                                                                   |                   | х        |                    | х                       |    |                            | х                 |                |               |  |
| Хөрс доройтох, цөлжих эсэх;                                                          |                   | х        |                    | х                       |    | х                          |                   |                |               |  |
| Ургамлан нөмрөг, ой мод өртөх эсэх                                                   |                   | х        |                    | х                       |    | х                          |                   |                |               |  |
| Ховор, нэн ховор ургамлын төрөл зүйл өртөх эсэх                                      |                   | х        |                    | х                       |    | х                          |                   |                |               |  |
| Зэрлэг амьтдын амьдрах орчныг доройтуулах, эсэх;                                     |                   | х        |                    | х                       |    | х                          |                   |                |               |  |
| Ховор болон нэн ховор амьтан өртөх, эсэх;                                            |                   | х        |                    | х                       |    | х                          |                   |                |               |  |

| Нийгмийн нөлөөллийн урьдчилсан үнэлгээнд авч үзсэн асуудлууд:                  |   |   |   |   |   |   |   |   |   |
|--------------------------------------------------------------------------------|---|---|---|---|---|---|---|---|---|
| Газар эзэмших, ашиглах эрх зөрчигдөх, эсэх;                                    | х |   |   |   | х |   |   | х |   |
| Оршин суугчдын нийгмийн байдалд сөрөг нөлөөтэй, эсэх;                          |   |   | х |   | х |   | х |   |   |
| Нөлөөлөлд өртөж болзошгүй төв суурин газар байгаа, эсэх;                       |   | х |   |   | х |   | х |   |   |
| Нүүлгэн шилжүүлэх асуудал үүсэх эсэх;                                          | х |   |   | х |   |   |   | х |   |
| Түүх соёлын өвд үзүүлэх нөлөөлөл                                               | х |   |   |   |   | х |   | х |   |
| Нутгийн иргэд, оршин суугчдын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх, эсэх;             |   | х |   |   | х |   |   | х |   |
| Төслийн бүхий л үе шатанд хүний эрүүл мэнд, амь насанд сөргөөр нөлөөлөх, эсэх; |   | х |   |   | х |   |   |   | х |

Дээрх үр дүнгээс харахад 22 нөлөөллийн 7 нь шууд, 14 нь шууд бус харин 2 нь өөрөөр зохицуулагдах хэлбэртэй байна. Нийт нөлөөллийн 50% нь нөлөөлөлгүй буюу багатай, 40.9% нь дунд зэргийн нөлөөлөлтэй байхад 9.09% нь их нөлөөлөл үзүүлж байна. Нөлөөллийн үр дүнгийн 63.6% нь түр зуурын ба богино хугацааных бол 36.36% нь урт хугацааны нөлөөлөл байна.

Иймээс байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөг төслийн үйл ажиллагаа, орон нутгийн онцлогтой холбож боловсруулан мөрдөж ажиллах шаардлагатай.

| Нөлөөллийн төрөл                                                                                  | Эрчим | Үргэлжлэх | Хамрах хүрээ | Магадлал | Нийт оноо | Онооны хувь | Нөлөөллийн зэрэг |
|---------------------------------------------------------------------------------------------------|-------|-----------|--------------|----------|-----------|-------------|------------------|
| <b>1. Байгалийн төрөл зүйлийн өөрчлөлт</b>                                                        |       |           |              |          |           |             |                  |
| Цаг уур уур амьсгалын өөрчлөлт                                                                    | 2     | 3         | 1            | 2        | 8         | 32          | Дунд             |
| Усны чанарын өөрчлөлт                                                                             | 2     | 3         | 1            | 2        | 8         | 32          | Дунд             |
| Ургамлын бүтцийн өөрчлөлт                                                                         | 2     | 3         | 1            | 3        | 9         | 36          | Дунд             |
| Хөрсний элэгдэл, эвдрэл, бохирдол                                                                 | 4     | 3         | 1            | 4        | 12        | 48          | Дунд             |
| Геологийн тогтоцын өөрчлөлт                                                                       | 2     | 3         | 1            | 1        | 7         | 28          | Бага             |
| Зэрлэг, ан амьтдын орон зайн өөрчлөлт                                                             | 1     | 3         | 1            | 2        | 7         | 28          | Бага             |
| Агаарын орчин /бохирдол/                                                                          | 8     | 3         | 1            | 4        | 16        | 64          | Дунд             |
| Газар доорх усны нөөц                                                                             | 6     | 3         | 2            | 3        | 14        | 56          | Дунд             |
| <b>Дундаж</b>                                                                                     |       |           |              |          |           | <b>40.5</b> | Дунд             |
| <b>2. Байгалийн нөөцийн ашиглалт</b>                                                              |       |           |              |          |           |             |                  |
| Газрын гадаргын нөөц баялаг                                                                       | 2     | 3         | 1            | 1        | 7         | 28          | Бага             |
| Бэлчээр, тэжээлийн байдал                                                                         | -     |           |              |          |           |             | -                |
| Эрдэс түүхий эдийн нөөц                                                                           | 6     | 3         | 2            | 5        | 16        | 64          | Дунд             |
| <b>Дундаж</b>                                                                                     |       |           |              |          |           | <b>46.0</b> | Дунд             |
| <b>3. Байгаль орчны чанар, нийгмийн өөрчлөлт</b>                                                  |       |           |              |          |           |             |                  |
| Ундны усны чанар, хэмжээ                                                                          | 4     | 3         | 1            | 2        | 10        | 40          | Дунд             |
| Хөрсний бохирдол                                                                                  | 6     | 3         | 2            | 3        | 14        | 56          | Дунд             |
| Агаарын чанар                                                                                     | 8     | 3         | 2            | 5        | 18        | 72          | Дунд             |
| Дуу чимээ, шуугианы нөлөөлөл                                                                      | 6     | 3         | 1            | 4        | 14        | 56          | Дунд             |
| Дэд бүтцийн хөгжилд нөлөөлөх                                                                      | +     |           |              |          |           |             | +                |
| Орон нутгийн нийгэм эдийн засагт нөлөөлөх                                                         | +     |           |              |          |           |             | +                |
| <b>Дундаж</b>                                                                                     |       |           |              |          |           | <b>56.0</b> | Дунд             |
| <b>4. Байгалийн цогцолборт газар, түүх соёлын дурсгалт зүйл, соёлт давхаргад үзүүлэх нөлөөлөл</b> |       |           |              |          |           |             |                  |
| Байгалийн үзэсгэлэнт төрх өөрчлөгдөх                                                              | -     | -         | -            | -        | -         | -           | -                |
| Ландшафтын хэлбэр, өнгө өөрчлөгдөх                                                                | -     | -         | -            | -        | -         | -           | -                |
| Тусгай хамгаалалтай ба цогцолбор газарт нөлөөлөх                                                  | -     | -         | -            | -        | -         | -           | -                |
